



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2017 ОНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА

АЛТАЙ ХОТ
2017 ОН

Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол Улс
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СХС	Сум хөгжлийн сан
НББ	Нягтлан бодох бүртгэл

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн тайлангийн аудит нь аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимууд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах зорилготой.

Аудит хийхдээ Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, 4100-4200, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлаж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх үүргийн хэмжээнд Төсвийн тухай хуулийн 8.9 дэхь заалтад хамрагдах 193 байгууллагын 273 санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийхээс 135 санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор, шинжээч нар, 27 санхүүгийн тайланд хувийн аудитын компаниар гэрээний үндсэн дээр аудит хийлгэхээр, ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар 79 санхүүгийн тайланд түүвэрт хамруулахаар, 32 санхүүгийн тайланд итгэл үзүүлэхээр МУ-ын Ерөнхий аудитаторын тушаалаар батлагдсан.

ХОЁР: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАХ АУДИТЫН ОНЦЛОГ

2017 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын өмнө жилийн аудитаас ялгарах давуу талуудыг дурьдвал:

- ✓ Тухайн онд санхүүгийн тайлангийн аудитыг шинэчилсэн СТАУС-2 программаар хийж гүйцэтгэсэн бөгөөд энэхүү программын онцлог нь санхүүгийн тайлангийн уялдааг шалгах горим нэмэгдсэн дэвшилтэт талтай юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт нийт 79 санхүүгийн тайланг хамруулан ТЕЗ-ийн тайланд нэгтгэж аудит хийсэн.
- ✓ 3 жил дараалан Зөрчилгүй дүгнэлт авч шалгуур үзүүлэлтэд нийцсэн 32 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн.
- ✓ Сүүлийн 3 жил данс бүрд аудит хийсэн, мөн 2016 оны төсвийн онцлог байдлыг харгалзан үзэж салбар, нэгж байгууллагын хувьд орлого зардлын дансдыг түүвэрлэн аудит хийж дүгнэлт гаргалаа.
- ✓ Санхүүгийн тайлангийн бодлого, шийдвэр гаргах, түүвэрт хамруулах байгууллагуудын талаар ажлын баримт боловсруулж хамт олны хурлаар хэлэлцүүлэн баталж хэрэгжүүлж ажилласан.

ГУРАВ: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ ХИЙХЭД БАРИМТАЛСАН БОДЛОГО, ХИЙГДСЭН АЖЛУУД, АУДИТ ХИЙХЭД УЧИРСАН БЭРХШЭЭЛ

Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлага, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит хийхэд баримтлах бодлого, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд өгөх шийдвэрийн төслийг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дээрх бодлогын баримт бичгүүдийг тусгасан нэгж байгууллагын аудитын төлөвлөгөөний хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхдээ дараахь горим, сорилуудыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн аудит хийхдээ өмнөх онуудын аудитын шийдвэрийг хэрэгжилтийг давтан үзсэн. Мөн Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж аудитын тайланд тусгасан.

2. Мөнгөн гүйлгээний журналыг excel файлд хөрвүүлэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, гүйлгээ баланс, ажлын баримттай тулган аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.
3. Санхүүгийн тайлангийн толилуулгыг анхан шатны баримтаар гарсан гүйлгээтэй тохирч байгаа эсэхийг нотлохын тулд түүвэрлэж үзсэн зардлын хувьд анхан шатны баримтаас зардлын зүйл ангийн дагуу төрийн сангийн хуулгыг дахин боловсруулж, НББ, санхүүгийн тайлан, илчлэл тодруулгуудын дүнтэй тулган баталгаажуулсан.
4. Төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудтай харилцдаг аж ахуйн нэгж байгууллагуудаас өр, авлагын судалгааг авч аудитад ашиглан авлага, өглөгийг насжилт, зардлын зүйл анги, харилцагч бүрээр ангилж дүн шинжилгээ хийлээ.
5. Орон нутгийн орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн байгууллагын тайлагнах орлого төлсөн татварыг Татварын хэлтэст тайлагнасан дүнтэй тулган баталгаажууллаа.
6. Шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон цалингийн нөхөн олговрын судалгааг хийж санхүүгийн тайлангийн авлага, өглөгтэй тулгалт хийлээ. Төсөвт бодитойгоор хохирол учруулсан болон цаашид хохирол учруулах нь илэрхий болсон мөнгөн дүнг тооцож холбогдох байгууллагуудад зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.
7. Орон нутгийн өмчийн газраас аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтаас бий болсон хөрөнгө, хөрөнгөтэй холбоотой эрх бүхий байгууллагын шийдвэр, хөрөнгийн хөдөлгөөний судалгааг авч тулган баталгаажуулсан.
8. Зөрүүтэй болон алдаатай дансны бичилтийг тодруулж нягтлан бодогчтой харилцан ярилцсаны үндсэн дээр залруулга хийлгэж санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнууллаа.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд гарсан бэрхшээлтэй асуудлууд:

1. Интернетийн хурд удаан байсан тул СТАУС программын ажилбаруудыг хийж гүйцэтгэхэд цаг хугацаа их алдсан.
2. Санхүүгийн тайлангийн аудитаар хийж байгаа ажилбарууд их байгаа нь аудитын чанарт эерэг нөлөөтэй боловч хугацаанд сөргөөр нөлөөлж байна.
3. Санхүүгийн тайлан баталгаажуулах аудиттай зэрэгцэж УИХ-ын төсвийн байнгын хороодын захиалга, ҮАГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Улсын болон Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт түүний үр дүн”, “Засгийн газраас олгосон векселийн үр дүн”-д гүйцэтгэлийн, “ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт үр дүн”-д нийцлийн аудитыг зэрэгцүүлэн хийсэн тул ачаалал маш их байлаа.

ДӨРӨВ : САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН

Төрийн аудитын газрын хэмжээнд 162 санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийж дүгнэлт гаргахаас төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 санхүүгийн тайлан, шууд захирагчийн 110 санхүүгийн тайлан, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 20 санхүүгийн тайлан, 21 төсөл сан хөтөлбөр, 6 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн нийт 158 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа.

“Эрүүл-Ус” ОНӨААТҮГ, “Зураг зүйн товчоо” ОНӨААТҮГ, “Орон сууц” ОНӨААТҮГ Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлан, холбогдох баримт материалаа ирүүлээгүй, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн алба нэгдсэн, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих инкубатор төв үйл ажиллагаа явуулаагүйгээс дүгнэлт гаргаагүй бөгөөд “Цөм сүрэг” төрийн өмчит аж ахуйн нэгжийн тайланд аудит хийсэн болно.

Санхүүгийн тайлангийн аудитаас 26 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд одоогоор тухайн аудитын байгууллагын гэрээг дүгнэх шатандаа ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар 93 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 54 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 11

санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч 22,166.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 5,682.0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулан, 1,211.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,306.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 2,418.6 сая төгрөгийн зөрчилд 47 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 2,547.7 сая төгрөгийг зөрчилд зөвлөмж хүргүүлж, 1,937.5 сая төгрөгийн санхүүгийн, 154 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэсэн байна.

4.1.1 Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийг төсвийн захирагчаар нь авч үзвэл:

№	Төсвийн ангилал	Дүгнэлт		
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг
1	ТШЗ	73	31	6
2	ТТЗ	16	4	
3	ТЕЗ	1		
3	Төсөл, сан	1	17	3
4	ТӨҮГ	1	1	
5	ОНӨҮГ	1	1	2
нийт дүн		93	54	11
Хувь		59%	34%	7%

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 158 санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 59 хувь буюу 93 Зөрчилгүй дүгнэлт, 34.1 хувь буюу 54 Хязгаарлалттай дүгнэлт, 6.9 хувь буюу 11 Сөрөг дүгнэлтийг өгсөн байна.

4.1.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг төсвийн захирагчаар нь авч үзвэл:

№	Төсвийн ангилал	илрүүлс эн зөрчил	үүнээс							
			Залруулсан	Төлбөрийн акт	Албан шаардлага				Зөвлөмж	
					зөрчил арилгуулах	тоо	хариуцлага тооцох	тоо	мөнгөн дүн	тоо
1	ТШЗ	15,608.1	3,730.4	127.6	6,884.5	75	2,318.8	39	2546.7	77
2	ТТЗ	2,476.2	633.8	1.5	1,839.9	20		2	1.0	2
3	ТЕЗ	399.7			399.7	1				
3	Төсөл, сан	2,857.6	1,317.8	1,079.0	399.8	12	61.1	3		
4	ТӨҮГ	34.6			34.6	1				
5	ОНӨҮГ	790.4		3.4	748.3	2	38.7	3		
нийт дүн		22,166.6	5,682.0	1,211.5	10,306.8	111	2,418.6	47	2,547.7	79


Тайлант онд илэрсэн нийт зөрчлийн 70% буюу 15,608.1 сая төгрөгийг Төсвийн шууд захирагч эзэлж байна. Нийт тогтоосон төлбөрийн актны 89% буюу 1,079.0 сая төгрөгийг төсөл сан буюу Сум хөгжүүлэх сан, 11% буюу 127.6 сая төгрөгийг Төсвийн шууд захирагч эзэлж байна. Хүргүүлсэн албан шаардлагаас 72% буюу 9,203.2 сая төгрөгийг Төсвийн шууд захирагч, 14% буюу 1,839.9 сая төгрөгийг Төсвийн төвлөрүүлэн захирагч нар тус тус эзэлж байна.

4.1.3 Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийг салбар, нэгж байгууллагаар авч үзвэл:

№	Төсвийн ангилал	Дүгнэлт		
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг
1	ЗДТГ	10	7	
2	ИТХ		2	
3	ЕБС	9	6	4
4	СӨБ	15	7	1
5	ЭМТ	16	4	
6	УТБ	14	5	1
7	ОНТБ	9		
8	СХС		17	1
9	ТӨҮГ	1	1	
10	ОНӨҮГ	1	1	2
11	МХС, ТЭДС, ХЭДС	1		2
12	Төрийн сан	16	4	
13	ТЕЗ	1		
нийт дүн		93	54	11

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар Эрүүл мэндийн төвийн байгууллагуудын 80 хувь нь зөрчилгүй дүгнэлтийг авсан байхад, СХС-гийн 94.4 хувь нь хязгаарлалттай дүгнэлт, ЕБС-уудыг 21 хувь, ОНӨҮГ-ын 50 хувь нь сөрөг дүгнэлтийг авчээ.


4.1.4 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг салбар, нэгж байгууллагаар нь авч үзвэл:



Тайлант онд илэрсэн нийт зөрчлийн 24% буюу 5,267.7 сая төгрөгийг Ерөнхий боловсролын сургууль, 21% буюу 4,748.3 сая төгрөгийг Сумын ЗДТГ, 14% буюу 3,167.2

сая төгрөгийг Эрүүл мэндийн төв, 11% буюу 2,476.2 сая төгрөгийг Сумын төрийн сан, 7% буюу 1,590.2 сая төгрөгийг Сум хөгжүүлэх сан, 6% буюу 1,305.7 сая төгрөгийг Сургуулийн өмнөх боловсрол, 6% буюу 1,267.5 сая төгрөгийг Төсөл сан, 4% буюу 956.7 сая төгрөгийг Улсын төсөвт байгууллагууд тус тус эзэлж байна.

4.1.5 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийг сүүлийн 3 оноор зэрэгцүүлэн судалгаа хийж үзвэл:



Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил албан шаардлага, төлбөрийн актыг харьцуулж үзвэл: 2015 онд илэрсэн зөрчил, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага хамгийн өндөр байсан бол 2016 онд илэрсэн зөрчил 6,753.9 сая төгрөгөөр, тогтоосон төлбөрийн акт 64.5 сая төгрөгөөр, албан шаардлага 3,364.3 сая төгрөгөөр, хариуцлага тооцох албан шаардлага 28.0 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин зөвлөмж 9.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ТАВ: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН НИЙТЛЭГ АЛДАА ЗӨРЧИЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хураангуйлан харуулбал:

1. Хөрөнгө, бараа материалыг авсан хэмжээгээр нь тухай бүр орлого авдаггүй, нягтлан бодох бүртгэлд шууд зарлагаар бичилт хийдэг, зөрүүтэй үнээр орлого авдаг, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө зарж борлуулсан байна.
2. Цалингийн урьдчилгааг их хэмжээгээр олгож тухайн жилд суутган тооцоог хийгээгүй байна.
3. Үр дүнгийн урамшууллыг илүү, дутуу тооцдог, мөн урамшуулал, шагналт цалин, ур чадварын нэмэгдэл гэх мэтээр нэг ажлын үзүүлэлтээр давхардуулан хавтгайруулан олгосон байна.
4. Анхан шатны нотлох баримтгүйгээр төсвийн хөрөнгийг захиран зарцуулжээ.
5. Батлагдсан төсвийг бүлгийн дүнгээр, зардлын зүйлээр хэтрүүлэн зарцуулсан.
6. Харилцагчид төлөх төлбөрийг илүү, дутуу төлж санхүүгийн тайланд авлага, өглөгийг тусгадаггүй, тооцоо нийлж акт үйлдээгүй.
7. Тухайн жилийн орлогын тооцоог бодоогүй, НББ-д зөрүүтэй тусгасан.

8. Хүнсний материалын тендерт шалгараагүй иргэн, ААНБ-аас худалдан авалт хийсэн.
9. УИХ-ын 2016 оны 47-р тогтоолыг зөрчиж албан тушаалтны гар утасны зардал, тэмдэглэлт баяр ёслолд төсвөөс зарцуулсан.
10. Төрийн сангийн хяналт хангалтгүй, тэмдэг дарж баталгаажуулаагүй гүйлгээг төрийн сангийн программд шивж оруулсан байна.
11. Жолоочийн шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, замын хуудасгүйгээр зарцуулдаг.
12. Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохирол учруулсан
13. Хоол, үдийн цайны нормативт зардлыг хэтрүүлэн зарцуулдаг, хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлж чанар муудахаар нь акталсан.
14. Хяналтын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлдэггүй гарсан зөрчил дутагдлыг дахин давтан гаргадаг.
15. СХС-гийн зээлийн гэрээний дагуу зээлийн төлбөрийг төлүүлдэггүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж эрх үүргээ биелүүлдэггүй.
16. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээгээр нийлүүлсэн тракторын үнийг буцаан төлөлтийг тооцоход гэрээт хугацаанд төлүүлээгүй, гэрээний дагуу алдангийг тооцоогүй байна.
17. Батлагдсан орон тооноос илүү хүн ажиллуулсан байна.

Дээрх алдаа зөрчлүүд үүсэх болсон шалтгаан:

1. Байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарын санхүүгийн мэдлэг дутмаг, санхүүгийн зөрчил гаргасан, хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох асуудал туйлын хангалтгүй байна.
2. Санхүүгийн албаны дотоодын хяналт сул албан тушаалтнууд эрх, үүргийнхээ хүрээнд заримч шаардлага тавьж ажиллаж чадахгүй байна.
3. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо хангалтгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн орлогыг илүү дутуу төвлөрүүлэх, тайлагнах зэрэг зөрчил үүсч байна.
4. Төсвийн төлөвлөлтийг бодит мэдээлэлд үндэслэж хийгээгүйгээс жилийн эцэст үүссэн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулж байна.
5. ОНӨААТҮГ-уудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт байхгүй, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулаагүй, гүйцэтгэлийг дүгнэж үр дүнг хэлэлцэхгүй байгаа нь алдагдалтай ажиллах, алдагдлыг төсвөөс нөхөх сөрөг үр дагаварыг бий болгож байна.
6. Төрийн өмнөөс гэрээ байгуулж гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээний гүйцэтгэл, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд тавих хяналт туйлын хангалтгүй, хариуцсан албан тушаалтнууд гэрээний эрх, үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

ЗУРГАА: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх үүргийн хэмжээнд Төсвийн тухай хуулийн 8.9 дэхь заалтад хамрагдах байгууллагуудын санхүүгийн аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараахь арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

1. Мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн сургалт, шалгалтыг чанартай зохион байгуулж санхүүчдийн мэдлэг, ёс суртахуун, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх
2. Аудитаар илэрсэн зөрчилийг арилгах, актыг барагдуулах ажлыг зохион байгуулж төсвийг хохиролгүй болгох арга хэмжээ авч үр дүнг тооцох

3. Төрийн аудитын байгууллагын өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын санхүүгийн зөрчил дутагдал гаргахгүй байх үндэслэл болно гэдгийг ухамсарлаж ажиллах
4. Эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай хийж тооцоог бодож санхүүгийн тайланд тусгах
5. Төсвийн төлөвлөлтийг хэрэгцээ шаардлагыг тооцсоны үндсэн дээр оновчтой бодитой тооцон, хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах
6. СХС-гийн зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлж түүнд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэх ажил зохион байгуулах нь нэн чухал асуудал болж байна.
7. Байгууллагуудын хүнсний материалын худалдан авалт, гэрээний үнэлгээнд хяналт тавьж ажиллах
8. Хуулийн дагуу хязгаарлалттай, сөрөг дүгнэлт авсан байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох
9. Санхүүгийн тайландаа хуулийн хугацаанд аудит хийлгээгүй байгууллагын удирдлагад хуулийн дагуу хариуцлага тооцох
10. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих инкубатор төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг судалж шийдвэрлэх

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР